

ТАНИЛЦУУЛГА

*“Онцгой байдлын ерөнхий газрын гал
унтраах тусгай зориулалтын машин
нийлүүлэх төсөл”-ийн тухай*

1. Төслийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол

Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах, аврах ангийн нэг аврагч, гал сөнөөгч дунджаар 32.1 км² талбайд байрлах эд хөрөнгө, иргэдийг хамгаалахаар үүргээ гүйцэтгэж байна. Үүнийг олон улсын дундаж хэмжээтэй харьцуулахад 2 дахин их талбай ногдож байгаа бөгөөд цаашид гал түймэр унтраах ангийг хүчин чадал өндөртэй шинэ үеийн тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай байна.

“Гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах /2000м³, 5000м³ болон түүнээс дээш/, шатахуун түгээх станцууд, томоохон хэмжээний худалдааны төвүүдэд гарсан гал түймрийг унтраах чадавх сайжирна.
- Аюулт үзэгдэл, ослын голомтод түргэн шуурхай очих, цаг алдалгүй түргэн шуурхай аврах, гал түймэр унтраах үйл ажиллагаа сайжирна.

2. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хүрээ

Төсөл хэрэгжүүлэгч: Онцгой байдлын ерөнхий газар

Төсөл хэрэгжих хугацаа: 2023 он–2026 он /3 жил/

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас олгох 13.3 сая еврогийн зээл нь жилийн 0.282 хувийн хүүтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй. Төслийн хүрээнд хийгдэх ажлын төсөвт өртгийн задаргааг доорх хүснэгтэд харуулав:

		/сая евро/
№	Хийх ажил	Төсөвт өртөг
1	Хөөсөөр гал түймэр унтраах автомашин /3ш/	2.0
2	Хөөс үүсгэгч бодис	0.3
3	Автомеханик шатны автомашин /32м – 10ш/	7.0
4	Автомеханик шатны автомашин /42м – 5ш/	4.0
Нийт		13.3

3. Бодлогын баримт бичигт туссан байдал

“Гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл” нь дараах бодлогын баримт бичигт туссан болно. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.20-д “Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд сансрын болон бусад

дэвшилтэт арга технологи, техник хэрэгсэл, багаж төхөөрөмж нэвтрүүлж, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ" гэж;

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.11-д "Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна." гэж тус тус заасан байна.

4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2023-2024 оны хооронд эдийн засаг харгалзан 6.0 хувь, 7.0 хувиар өсөж, Монгол Улсын 2023 оны төсөв, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 44.3 хувь, 2024 онд 42.7 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР